

Монгол Улсад дотоодын нийт бүтээгдэхүүнийг тооцож буй статистикийн аргачлалыг боловсронгуй болгох зарим асуудал

Б. Батмөнх

МУИС-ийн ЭЗС-ийн Статистикийн тэнхмийн эрхлэгч, доктор

ДНБ нь улс орны эдийн засгийн цар хэмжээ, түүний өсөлт, ард түмний амьжиргааны түвшинг илэрхийлдэг макро эдийн засгийн хамгийн чухал үзүүлэлтийн хувьд их бодитой, үнэн зөв тооцогдсон байх шаардлагатай. ДНБ-д харьцуулсан олон үзүүлэлтийг төрийн бодлого боловсруулахад өргөн ашигладаг. Иймд ДНБ-ийг олон улсын статистикийн стандартын дагуу үнэн зөв тооцох, олон улсын хэмжээнд тогтоосон арга зүйг хэрэглэх асуудал манайд чухал асуудлын нэг болоод байна. Энэ нь урьд өмнө мэргэжлийн цөөн хүмүүсийн дунд яригддаг боловч ил тод хөндөгдөөгүй явсаар ирсэн сэдэв юм.

Энэхүү судалгааны ажилд Монгол Улсын ДНБ-ийг тооцох арга зүйн хүрээнд тулгамдсан асуудлыг хөндөж, ДНБ-ий тооцоог сайжруулах, олон улсын аргачлалд нийцүүлэх талаар хэд хэдэн асуудлыг гаргаж тавьсан. Тодруулбал, төлийг мал аж ахуйн бүтээгдэхүүнээр шууд авдгаас болж, мал өссөн жил улсын хэмжээний нийт үйлдвэрлэлтийн хэмжээ болон хөдөө аж ахуйн салбарын нэмэгдэл өртөг шууд хамааралтай даган өсч байна. Иймд, малын өсөлт үржилтийн бүтээгдэхүүнийг цаашид мал аж ахуйн салбарын нийт үйлдвэрлэлтийн тооцоонд оруулахдаа зарим өөрчлөлт оруулах, тухайлбал, төлийг шууд үнэлж бүтээгдэхүүнд оруулж ирснийг зогсоох, өмнөх онуудын тооцооноос түүнийг хасаж, засвар өөрчлөлт оруулах; нийт малыг дуусаагүй үйлдвэрлэлийн оны эхний эсвэл эцсийн үлдэгдлийн өөрчлөлт хэлбэрээр бүтээгдэхүүний тооцоонд тусгах; мал аж ахуйн салбарын нийт үйлдвэрлэлтийг голлон мал, тэжээвэр амьтдын гаралтай бүтээгдэхүүн болох мах, сүү, өндөг, ноос, ноолуур, арьс, шир, зөгийн бал гэх мэт өрхийн аж ахуйн дотоод хэрэгцээнд ашигласан болон зах зээлд нийлүүлсэн эцсийн бүтээгдэхүүний хэмжээгээр тооцдог зарчимд шилжихийг санал болгосон.

Түлхүүр үгс:

Дотоодын нийт бүтээгдэхүүн, Үндэсний тооцооны систем, мал аж ахуйн салбар, нийт үйлдвэрлэл, зэрэгцүүлэх үнэ

1. Сэдвийн ач холбогдол

Монгол Улс 1990 оноос зах зээлийн эдийн засгийн харилцаанд шилжилт хийж, 1992 оноос олон улсын банк, санхүүгийн байгууллагуудын гишүүн болсноор өөрийн орны талаархи статистик мэдээллийг олон улсын байгууллагуудад нийтлэг жишиг аргачлалаар бэлтгэж өгч байх шаардлага зүй ёсоор тавигдсан юм. Түүнчлэн, дотооддоо ч олон улсын статистикийн стандартыг

нэвтрүүлж, зах зээлийн эдийн засгийн нөхцөлд тохирсон статистикийн арга зүйг хэрэглэх, олон улсын түвшинд өөрийн орны үзүүлэлтүүдийг зэрэгцүүлэх шаардлага гарсан билээ.

Хуучин социалист системийн улс орнуудын статистикийн арга зүйн гол цөм нь улс ардын аж ахуйн балансын систем байв. Статистикийн энэхүү арга зүйн онолын

үндэс нь Адам Смитын “бүтээлч хөдөлмөр” гэдэг ойлголтоос эх үүсвэртэй, хожим Карл Марксын материаллаг баялаг гагцхүү үйлдвэрлэлийн хүрээнд бий болдог гэсэн онолын үзэл баримтлалд үндэслэж байв. Иймээс бид 1990 оноос өмнө үндэсний орлогыг зөвхөн материаллаг үйлдвэрлэлийн хүрээнд тооцдог байжээ. Тэр үеийн үндэсний орлого одоогийн дотоодын нийт бүтээгдэхүүн (ДНБ)-ээс ихээхэн өөр, ойлголт, тодорхойлолт төдийгүй тооцох арга зүйн хувьд ч ихээхэн ялгаатай байлаа. Статистикийн үзүүлэлт тооцох аргачлалыг төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгийн үед тэр үеийн Эдийн Засгийн Харилцан Туслалцах Зөвлөлийн гишүүн орнуудын Статистикийн Байнгын Комиссоос батлан гаргадаг байв. Иймээс төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засагтай орнууд арга зүйн хувьд нэгдсэн, зохицуулсан, түүнийг нэгдсэн журмаар боловсруулдаг тогтолцоотой байсан юм.

Харин зах зээл хөгжсөн орнуудад Үндэсний Тооцооны Систем (ҮТС)-д тулгуурласан статистикийн арга зүйг хэрэглэж хэвшсэн, одоо ч хэрэглэсээр байна. Энэ нь дээрх бидний 1990 оноос өмнө хэрэглэж байсан аргачлалаас зарчмын ялгаатай, эдийн засгийн үйл ажиллагааны өргөтгөсөн онолд тулгуурласнаараа онцлогтой байв.

Бид төвлөрсөн төлөвлөгөөт тогтолцоо нуран унаснаас хойш ҮТС-д тулгуурласан статистикийн цоо шинэ арга зүйд шилжиж, өнгөрсөн 17 жилд тодорхой амжилтанд хүрсэн хэдий боловч одоо ч засаж сайжруулах зүйл цөөнгүй, олон улсын нийтлэг аргачлалаас зөрүүтэй үзүүлэлт байсаар байна.

Үүнийг судлаж, олон улсын статистикийн стандартыг нэвтрүүлэх нь одоогийн Үндэсний Статистикийн Хороо (ҮСХ), энэ

чиглэлээр ажиллаж байгаа статистикийн мэргэжилтнүүдийн гол үүрэг юм.

Ер нь аливаа улс орны статистикийн системийн хөгжлийг олон улсын хүлээн зөвшөөрөгдсөн стандартаргазүй, аргачлалыг хэрэглэж байгаагаар нь хэмждэг жишиг аль хэдийнээ тогтсон байдаг. Харамсалтай нь манай оронд статистикийн мэргэжлийн бус хүмүүс статистикийн үзүүлэлтийн ойлголт, тодорхойлолт, арга зүйн талаар мэддэггүй, түүнд ач холбогдол огт өгдөггүй. Үүний тод жишээ Мянганы Хөгжлийн Зорилтуудыг дүгнэх үзүүлэлт дээр тод харагддаг.

НҮБ-аас Мянганы Хөгжлийн Зорилтуудын хэрэгжилтийг үнэлж дүгнэх үзүүлэлтүүдийг зорилт болгоноор хэлэлцэн тогтоож, түүний ойлголт, тодорхойлолт, тооцох арга зүйг батлан гаргасан байдаг. Улс орнууд энэхүү стандарт арга зүйг мөрдөж, өөрийн улс орны түвшинд дээрх аргачлалаар, тогтсон үзүүлэлтээр зорилтын хэрэгжилтийг дүгнэж байна. Гэтэл манай яамдууд өөрсдийн мэдээлэлд үндэслэн тэдгээр зорилтуудыг дүгнэх үзүүлэлтийг өөрсдөө дур мэдэн нэмж, өөрчилж гаргаад УИХ-ын тогтоолоор батлуулсан байна. Эдгээр үзүүлэлтийн зарим нь бүр албан ёсны статистикт байхгүй, өөрсдийнх нь дотоод мэдээллээр гардаг үнэн зөв нь их эргэлзээтэй, баталгаа муутай тоо мэдээллүүд байна. Ингэхлээр Монгол Улсын Мянганы Хөгжлийн Зорилтуудын хэрэгжилтийг дэлхийн бусад улс орнуудтай жиших ямар ч боломжгүй болж байгаа бөгөөд энэ үзүүлэлтийн жагсаалтад нь НҮБ-аас гаргасан олон үзүүлэлт ороогүй орхигджээ. Тэгэхлээр эдгээр үзүүлэлтийг Монгол Улс дүгнэхгүй, гаргахгүй болж таарч байгаа юм.

Миний бие энэхүү ажилдаа Монгол

Улсын ДНБ-ийг тооцох арга зүйн хүрээнд тулгамдсан, сайжруулах арга зүйн асуудлыг хөндсөн бөгөөд статистикийн салбарт олон жил ажилласан, энэ чиглэлээр мэргэжил эзэмшсэн хүний хувьд уг асуудлыг цаашдаа шийдвэрлэх шаардлагатай нэн тулгамдсан асуудал гэж үзэж байна.

ДНБ нь улс орны эдийн засгийн цар хэмжээ, түүний өсөлт, ард түмний амьжиргааны түвшинг илэрхийлдэг макро эдийн засгийн хамгийн чухал үзүүлэлтийн хувьдих бодитой, үнэн зөв тооцогдсон байх шаардлагатай. Нөгөөтэйгүүр, ДНБ-д харьцуулсан олон үзүүлэлтийг төрийн бодлого боловсруулахад өргөн ашигладаг. Жишээлбэл, ДНБ-д эзлэх төсвийн зарлагын хувиар эдийн засаг дахь төрийн оролцоо, Засгийн газрын зардлын хэмжээг үнэлдэг бол ДНБ-д эзлэх татварын орлогын хувиар татварын дарамтыг хэмждэг. Нэг хүн амд ногдох ДНБ-ээр улс орны хөгжлийн түвшинг хэмждэгийг бид мэднэ. Эндээс харахад ДНБ-ний хэмжээг буруу тооцох нь ямар үр дагаварт хүргэж, буруу дүгнэлт үнэлгээ өгөхөд хүргэх нь тодорхой юм. Энэ утгаараа ДНБ-ийг олон улсын статистикийн стандартын дагуу үнэн зөв тооцох, олон улсын хэмжээнд нэг мөр тогтоосон арга зүйг хэрэглэх асуудал чухал тулгамдсан асуудлын нэг болоод байна. Энэ асуудал нь урьд өмнө мэргэжлийн цөөн хүмүүсийн дунд яригддаг боловч ил тод хөндөгдөөгүй явсаар ирсэн сэдэв юм.

2. ДНБ-ний тооцоо болон үндэсний тооцооны системд шилжих талаар хийгдсэн ажлууд

Монгол Улсын Засгийн Газар 1991 оны 3-р сарын 2-ны өдөр 71-р тогтоолоороо УТС-д шилжих бэлтгэл хангах шийдвэрийг гаргасан. 1994 онд “Статистикийн тухай” Монгол Улсын хуулийг парламент батлаж,

уг хуулийг хэрэгжүүлэх тухай Засгийн газрын 94-р тогтоол 1994 оны 5 сард гарсан бөгөөд энэхүү тогтоолоор олон улсын статистикийн стандартад шилжих хөтөлбөрийг баталсан. Энэхүү хөтөлбөрийн нэг гол хэсэг нь үндэсний тооцооны системийг манай орны статистикийн практикт нэвтрүүлэх ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлэх явдал байлаа.

Манай орны статистикийн практикт УТС-ийг нэвтрүүлж ирсэн ажлыг дараахь 3 гол үе шатанд хуваан авч үзэх нь зүйтэй. Үүнд:

I үе шат: 1989-1995 он

II үе шат : 1996-1998 он

III үе шат : 1999 оноос хойшхи

Дотоодын болон үндэсний нийт бүтээгдэхүүнийг УТС-ийн аргачлалаар тооцох анхны тооцоо бүр 1989 онд хийгдсэн юм. Тэр үеийн эдийн засгийн гол үзүүлэлт болсон нийгмийн нийт бүтээгдэхүүн, үндэсний орлогыг дотоодын болон үндэсний нийт бүтээгдэхүүн болгон шилжүүлэх тусгай тооцооны аргыг хэрэглэж байлаа. Энэ аргыг тухайн үедээ хуучин Зөвлөлт Холбоот Улсад хэрэглэж байсан бөгөөд бид тухайн үед ЗХУ-ын Статистикийн хорооноос боловсруулсан аргачлалыг ашиглаж байв. Энэ аргаар тооцох тооцоог сайжруулж, хамрах хүрээг өргөжүүлэн 1995 он хүртэл шилжүүлэн тооцох аргыг ашиглаж ирсэн юм.

Эхний үе шатанд УТС-ийн онол арга зүйг судлах, орчуулах, манай орны нөхцөлд дотоодын болон үндэсний нийт бүтээгдэхүүнийг тооцох аргачлалыг боловсруулах, эдгээр үзүүлэлтийг үйлдвэрлэлийн аргаароны болон зэрэгцүүлэх үнээр тооцох тооцоог 1980-оноос хойш хийх зэрэг ажлуудыг хийж гүйцэтгэсэн. Харин 1993 онд ДНБ-ийг эцсийн ашиглалтын аргаар, 1994 онд хүчин зүйлийн орлогын

нийлбэр байдлаар анх тооцсон юм. Энэ бол ҮТС-ийг нэвтрүүлэх ажлын анхдагч маш чухал үе байсан.

Хоёрдогч шат 1996 оноос эхэлсэн гэж үзэх нь зүйтэй болов уу. Учир нь 1995 оны гүйцэтгэлээр 1996 онд ДНБ-ийг улсын тайлан мэдээг үндэслэн шууд тооцох аргыг хэрэглэж эхэлсэн. 1995 он хүртэл ашиглаж байсан шилжүүлэн тооцох тооцооны аргыг үйлдвэр, аж ахуйн газруудаас цуглуулсан мэдээ тайланг үндэслэн шууд тооцох аргаар сольсон нь энэ ажлын шинэ үе шат гэж үзэж болохоор зарчмын ахиц гарсан үе байлаа. Дээр дурдсан статистикийн олон улсын стандартад шилжих хөтөлбөрийн хүрээнд ҮТС-ийг нэвтрүүлэх ажлыг энэ үе шатанд улам эрчимтэй хэрэгжүүлж ирсэн. Мөн эдийн засгийн үйл ажиллагааны олон улсын салбарын стандарт ангилалд тулгуурласан үндэсний ангилал боловсруулах ажлыг 1995-1997 онд, салбар хоорондын балансыг ҮТС-ийн аргачлалаар боловсруулах бэлтгэл хангах, түүвэр судалгаа явуулах, маягт зааврыг боловсруулах ажлыг 1997-1998 онд хийж, ДНБ-ийг эдийн засгийн сектороор тооцох, аймгуудад ДНБ тооцох аргачлал боловсруулах ажлыг 1997-1998 онд тус тус хийж гүйцэтгэсэн. Хоёрдах үе шатанд ДНБ-ийг салбараар тооцох аргачлалыг улам боловсронгуй болгох, хамрах хүрээг нь сайжруулах, түүнийг улирлаар тооцох, нэлээд аймгууд өөрсдөө ДНБ-ийг аймгийнхаа хэмжээнд тооцдог болсон зэрэг ажлууд хийгдсэн болно. ҮТС-ийг нэвтрүүлэх ажлыг хариуцсан бие даасан нэгж болох Үндэсний тооцооны хэлтсийг 1997 оны 11-р сард хуучин макро эдийн засгийн хэлтсийн суурин дээр байгуулж, үүрэг, хариуцах ажлыг нь өөрчилсөн нь энэ ажлыг цаашид дагнан гүйцэтгэхэд чухал арга хэмжээ болсон юм.

Гурав дахь үе шат 1999 оноос эхэлсэн гэж үзэж болох бөгөөд энэ үе шатны онцлог нь ҮТС-ын хамгийн гол бүрэлдэхүүн хэсэг болсон үндэсний хэмжээний дансуудыг байгуулах, нөөц ашиглалтын хүснэгтийг боловсруулах ажлыг анх удаа хийж эхэлсэн нь ҮТС-ийг нэвтрүүлэх ажлын шинэ үе шат эхэлснийг харуулсан. 1999 оноос ҮТС-ийн голлох дансуудийг тодруулбал,

- үйлдвэрлэлийн
- орлого бүрдэлтийн
- орлогын анхны хуваарилалтын
- орлогын дахин хуваарилалтын
- орлого ашиглалтын
- хөрөнгийн
- бараа, үйлчилгээний

гэсэн 6 гол дансуудыг 1995-1997 оноор байгуулсны дотор хөдөө аж ахуйн 13 гол нэрийн бүтээгдэхүүнээр болон аж үйлдвэрийн 60 дэд салбараар бараа, үйлчилгээний 73 дансуудыг байгуулсан. 2000 онд 1999 оны гүйцэтгэлээр ДНБ-ийг аймгаар тооцдог болсноор улс орны эдийн засагт бүс нутгийн болон аймгуудын оруулах хувь нэмрийг тодорхойлох боломжтой болсон юм. Түүнчлэн, нөөц ашиглалтын хүснэгтийг туршилтын журмаар байгуулж, бараа, үйлчилгээний дансуудыг бий болгосон нь ДНБ-ний тооцооны үндэслэлийг сайжруулж, үйлдвэрлэлийн болон эцсийн ашиглалтын тооцоог уялдуулах зэрэг ач холбогдол бүхий ажил болсон юм. 2001 оноос үндэсний хэмжээний 6 гол дансыг эдийн засгийн сектороор, 1995-2000 оны гүйцэтгэлээр тооцсон нь сектороор дэлгэрэнгүй тооцоо хийсэн анхны оролдлого байлаа. Гуравдахь үе шатанд ДНБ-д хувийн хэвшлийн эзлэх хувь хэмжээг салбараар тооцдог болсон нь эдийн засаг дахь хувийн секторын эзлэх байр суурийг тодорхойлсон чухал үзүүлэлт болов. Гуравдагч үе шат өнөөг хүртэл үргэлжилж байгаа бөгөөд ҮТС-ийн үлдсэн

гол данснуудыг бүрэн байгуулж дууссанаар шувтрах болно гэж бид үзэж байна.

3. ДНБ-нийг тооцох арга зүйг сайжруулах тулгамдсан асуудлууд

Сүүлийн жилүүдэд Монгол Улсын нэг хүн амд ногдох ДНБ-ий хэмжээ огцом нэмэгдсэн нь нэг л итгэл үнэмшил төрүүлэхгүй байгаа билээ. Учир нь 2007 онд малын тоо толгой 40 саяд хүрч, хуучин аргачлалаараа ДНБ-ий хэмжээ ихээхэн нэмэгдсэн гарч байна. ДНБ-ий бодит өсөлтийг харуулах шалгуур нь бүтээгдэхүүн, үйлчилгээний биет хэмжээний өсөлт юм. Аж үйлдвэрийн салбарын гол нэр төрлийн бүтээгдэхүүний биет хэмжээ, тэр дотроо экспортын гол нэр төрлийн бүтээгдэхүүн болох зэсийн баяжмал, молибден, алт олборлолтын биет хэмжээ тийм ч ихээр өсөөгүй байна. Ингэхлээр үнийн өсөлт ДНБ-ий зэрэгцүүлэх үнийн тооцоонд нөлөөлсөн байж мэдэхээр байна.

ДНБ-ий хэмжээ огцом өссөн нь нэг талаас далд эдийн засгийн хэмжээг тооцож ДНБ-д оруулж байгаа гээд салбар бүрд нилээдгүй олон хийсвэр тооцоо нэмж өгсөн, нөгөө талаас үйлчилгээний салбаруудын бүтээгдэхүүнийг зэрэгцүүлэх үнээр үнэлэх аргачлал боловсронгуй биш байгаа нь нөлөөлсөн гэж үзэж болох юм.

Үндэсний тооцооны системд шилжих, ДНБ-ийг тооцох талаар багагүй ажил хийгдсэн боловч олон улсын аргачлалыг бүрэн нэвтрүүлэх талаар анхаарах зүйл цөөнгүй байна. ДНБ-ий тооцоог сайжруулах, олон улсын аргачлалд нийцүүлэх талаар хэд хэдэн асуудлыг нэн тэргүүнд хөндөх шаардлагатай байна. Үүнд:

1. Мал аж ахуйн салбарын нэмэгдэл өртгийг тооцож байгаа өнөөгийн аргачлал олон улсынхаас ихэд зөрүүтэйгээс ДНБ-ий хэмжээ буруу тооцогдсоор ирсэн.
2. Нягтланбодохын тайлан тэнцлийг үнэн зөв гаргахгүй, орлогоо нуух үзэгдэл газар авснаас ДНБ-ий тооцоонд дутуу хамрагдсан далд эдийн засгийн хэмжээ их байгаа. Нягтлан болох бүртгэлийн хууль зөрчиж 2-3 өөр тэнцэл гаргадаг байгууллагууд ч цөөнгүй бий. Тайлан тэнцлийг санаатайгаар буруу гаргах нь дотоодын нийт бүтээгдэхүүний тооцоонд шууд нөлөөлж, түүнийг чанаргүй үндэслэл муутай болгож байна. НҮБ-ын үндэсний тооцооны системийн 1993 оны аргачлалын дагуу ДНБ-ий тооцоонд далд эдийн засгийн хэмжээг тооцож тусгах асуудал ҮСХ-ны хувьд нэн тулгамдсан асуудлын нэг болж байгаа юм.
3. Бүтээгдэхүүний тооцоонд орон сууцны хийсвэр түрээс тооцох, мөн хүн хөлслөн ажиллуулдаг өрхийн аж ахуйн секторын мэдээлэл одоогоор бүрэн хамрагдахгүй байна.
4. Манай орон ДНБ-ий хэмжээг жилээр тооцсоор ирсэн. Цаашдаа ДНБ нийт бүтээгдэхүүнийг улирлаар тогтмол тооцдог болох шаардлагатай байна.
5. ДНБ-ий зэрэгцүүлэх үнийн тооцоог улам боловсронгуй болгож, олон улсын жишгээр давхар дефляторын аргыг нэвтрүүлэх, ялангуяа эцсийн ашиглалтын аргаар тооцсон ДНБ-ий бүрэлдэхүүн хэсгүүдийг зэрэгцүүлэх үнээр үнэлэх явдал чухал байна.

4. Мал аж ахуйн салбарын бүтээгдэхүүнийг олон улсын нийтлэг аргачлалаар тооцох асуудал

ДНБ нь маш энгийнээр тайлбарлахад жилийн хугацаанд эдийн засгийн бүх салбаруудад бий болсон нэмэгдэл өртөг билээ. Үйлдвэрлэлийн аргаар ДНБ-ийг тооцохдоо нэмэгдэл өртгийг тооцохын өмнө эхлээд тухайн салбарын нийт үйлдвэрлэлтийг тооцдог. Үүнээсээ завсрын хэрэгцээг хасаад салбарын нэмэгдэл өртгийг гарган авдаг. Манай статистикийн одоогийн практикт мал аж ахуйн бүтээгдэхүүнийг тооцохдоо 2 үндсэн хэсгээс бүрдэнэ гэж тооцсоор ирсэн. Үүнд:

1. Малын өсөлт үржилтийн бүтээгдэхүүн
2. Мал, тэжээвэр амьтдын гаралтай бүтээгдэхүүн, сүү, мах, өндөг, ноос, ноолуур, арьс, шир, зөгийн бал гэх мэт.

Малын өсөлт үржилтийн бүтээгдэхүүнийг

тооцохдоо шинээр гарсан төлийг шууд үнэлж, бүтээгдэхүүн гэж тооцдог бөгөөд үүн дээр малын нас дэвшилт, өсөлтийн бүтээгдэхүүн гэгчийг хийсвэрээр тооцон нэмдэг. Төлийг ийнхүү мал аж ахуйн бүтээгдэхүүнээр шууд авдгаас болж, мал өссөн жил мал аж ахуйн бүтээгдэхүүн, үүнийг дагаад улсын хэмжээний нийт үйлдвэрлэлтийн хэмжээ, цаашлаад ДНБ-ий хэмжээ ихээхэн нэмэгдэж гардаг. Үүнийг дараахь зургаас харж болно.

Зураг 1-ээс харахад мал өссөн жил хөдөө аж ахуйн салбарын нэмэгдэл өртөг шууд хамааралтай даган өссөн нь харагдаж байна. Мөн ган, зуд тохиолдсон 2000-2001 онуудад малын хорогдол нэмэгдсэн тул хөдөө аж ахуйн салбарын нэмэгдэл өртөг дагаад буурсан нь тодорхой харагдаж байна. Энэ 2 үзүүлэлтийн хоорондын хамаарлыг хэмжиж үзэхэд корреляцийн коэффициент $R=0.838$ гарч байгаа нь өөр хоорондоо ихээхэн хүчтэй хамааралтай байгааг харуулж байна.

Зураг 1. Хөдөө аж ахуйн нэмэгдэл өртөг ба малын тоо



Эх үүсвэр: ҮСХ-ны ХАА салбарын бүтээгдэхүүний тооцоо

ҮТС-д мал аж ахуйн салбарын нийт үйлдвэрлэлтийг үүнээс ихээхэн өөрөөр авч үздэг. ҮТС-93 аргачлалд шилжих талаар 1995 оноос нэлээд үе шаттай ажил хийж ирсэн боловч мал аж ахуйн нийт үйлдвэрлэлтийг тооцох манай аргачлал үндсэндээ хуучнаараа байгаа юм. ҮТС-93 аргачлалын 6.95-д идэшний зориулалтаар үржүүлж буй малыг дуусаагүй үйлдвэрлэл, харин нядалсан малыг л бүтээгдэхүүн гэж үздэг.

Нядлагдаагүй байгаа малыг үнэхээр хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн гэж үзэж болохгүй. Энд л онолын гол асуудал байгаа юм. Үндэсний тооцооны системд хүний хэрэгцээг хангах зориулалттай бэлэн болсон бүтээгдэхүүн, ажил үйлчилгээг нийт үйлдвэрлэлтэд хамруулдаг. Энэ агуулгаараа төл, том мал нь шууд хүнсэнд хэрэглэхэд бэлэн болсон бүтээгдэхүүн биш юм.

ҮТС-ын аргачлалаар ажлын болон ашиг шимийн малыг идэшний зориулалтгүй тул үндсэн хөрөнгө гэж үздэг (ҮТС, 1993-ын 10.83). Гэтэл манай оронд малыг дотор нь ингэж ялгадаггүй бөгөөд бүгдийг нь идэшний зориулалттай мэтээр авч үздэг.

Манай орны хувьд малыг ажлын болон ашиг шимийн мал гэж ялгах боломж үнэхээр муу, амьдрал дээр ялгах бараг боломжгүй байдаг тул бүгдийг нь дуусаагүй үйлдвэрлэлийн хэлбэрээр харуулахаас өөр арга байхгүй.

Энэ бүхнээс үзэхэд төл, том малыг мал аж ахуйн нийт үйлдвэрлэлтэнд үнэлж оруулж байгаа манай одоогийн аргачлал нь олон улсын стандарт ойлголт, тодорхойлолтоос зөрүүтэй байгаа нь тодорхой байна. Мал аж ахуйн бүтээгдэхүүнийг тооцож байгаа одоогийн аргачлалын муу тал нь мал аж

ахуйн салбарын үйлдвэрлэлт малын тоо толгойноос шууд хамааралтай, мал өссөн жил нэмэгддэг, мал олноор хорогдсон жил үйлдвэрлэлтийн хэмжээ ихээхэн буурдаг, өөрөөр хэлбэл, ихээхэн хэлбэлзэлтэй тооцоо гардагт оршдог. Нөгөө талаас, төл, том малыг нийт үйлдвэрлэлтэд оруулж байгаагаас тус салбарын нийт үйлдвэрлэлт, нэмэгдэл өртөг, цаашлаад ДНБ-ий хэмжээ хийсвэрээр нэмэгдэж тооцогдсоор ирсэн.

2006 оны мал аж ахуйн бүтээгдэхүүний тооцоогоор энэ салбарын нийт үйлдвэрлэлтийн 13 хувийг төл, 16 хувийг малын нас дэвшилт, өсөлтийн бүтээгдэхүүн, харин мал, амьтдын гаралтай бүтээгдэхүүн 71 хувийг эзэлсэн байна. Эндээс мала аж ахуйн салбарын нийт үйлдвэрлэлт 29 хувиар илүү тооцогдсон гэж үзэж болно. Ойролцоогоор тооцож үзэхэд 2006 оны ДНБ-ий хэмжээ төл, том малыг оруулснаас 5-6 хувиар илүү тооцогдсон байж болохоор байна.

Мала аж ахуйн салбарын нийт үйлдвэрлэлтийг тооцох ҮТС-ын дээрх аргачлалыг бүрэн нэвтрүүлэхийн тулд дараахь саналыг дэвшүүлж байна. Үүнд:

- Малын өсөлт үржилтийн бүтээгдэхүүнийг цаашид мал аж ахуйн салбарын нийт үйлдвэрлэлтийн тооцоонд оруулахдаа зарим өөрчлөлт оруулах, тухайлбал, төлийг шууд үнэлж бүтээгдэхүүнд оруулж ирснийг зогсоох, өмнөх онуудын тооцооноос түүнийг хасаж, засвар өөрчлөлт оруулах;
- Нийт малыг дуусаагүй үйлдвэрлэлийн оны эхний эцсийн үлдэгдлийн өөрчлөлт хэлбэрээр бүтээгдэхүүний тооцоонд тусгах;
- Мал аж ахуйн салбарын нийт үйлдвэрлэлтийг голлон мал, тэжээвэр

амьтдын гаралтай бүтээгдэхүүн болох
мах, сүү, өндөг, ноос, ноолуур, арьс,
шир, зөгийн бал гэх мэт өрхийн аж
ахуйн дотоод хэрэгцээнд ашигласан
болон зах зээлд нийлүүлсэн эцсийн
бүтээгдэхүүний хэмжээгээр тооцдог
зарчимд шилжихийг санал болгож
байна.

Ашигласан материал

Б.Батмөнх, 1995. Үндэсний тооцооны
систем, Улаанбаатар

Commission of the European Communities,
International Monetary Fund,

System of National Accounts, 1993.
UN, World Bank, Organisation
for Economic Co-operation and
Development

МУ-ын Засгийн Газрын 1991 оны 71
дүгээр тогтоол

МУ-ын Засгийн Газрын 1994 оны 94
дүгээр тогтоол

Монгол Улсын Статистикийн Эмхтгэл,
1995, 2000, 2005, 2007 он, Улаанбаатар
ҮСХ-ны ХАА салбарын бүтээгдэхүүний
1990-2006 оны дэлгэрэнгүй тооцоо